



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/26

Баян-Овоо сум

Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний
ажлын хэсгийг байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Боловсролын сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/115 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, Боловсролын яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Шалгалтын тов тогтоох тухай" 2/203, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/38 дугаар удирдамж, аймгийн боловсролын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/22 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Болортуяа

Сургалтын менежер

Гишүүд: Б.Энхболор

Бага ангийн багш

Ж.Цагаачин

Бага ангийн багш

А.Эрдэнэтуяа

Нийгмийн ажилтан

Ө.Золзодмаа

Эрүүл мэндийн багш

Д.Ганганцэцэг

Англи хэлний багш

Н.Ууганбаяр

Орос хэлний багш

Д.Түмэннаст

Эцэг эхийн төлөөлөл

Д.Бямбатогоо

Эцэг эхийн төлөөлөл

Э.Балжинням

Суралцагчийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Оюунтунгалаг

Дизайн технологийн багш

2. Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг сургуулийн түвшинд зохион байгуулах нэгдсэн удирдамжийг баримтлан удирдлага зохион байгуулалтаар ханган, анги танхим, техник хэрэгслийг бэлтгэх, үнэлгээний нарийвчилсан зураглал, төлөвлөгөө гарган эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд мэдээлэн аливаа ёсзүйн зөрчилгүй ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *Ч. Болормаа* Ч.БОЛОРМАА